



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/721.

Булган сум

Г Хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээн Г
зохион байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, Хүүхдийн эрхийн конвенцын 6 дугаар зүйлийн 6.2, 24 дүгээр зүйлийн 24.3, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны "Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" А/57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээн зохион байгуулахыг хориглосугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга болон аймаг, сумын Морин спорт уяачдын холбооны тэргүүн нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга (С.Оюунзаяа), Цагдаагийн газрын дарга (Г.Ганбаяр)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

